

## МОНГОЛЫН ЗАГАСЧЛАЛЫН СПОРТЫН ХОЛБООНЫ ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар Монголын загасчлалын спортын холбоо (цаашид “МЗСХ” гэх) -ны гишүүнчлэл, гишүүдийн хурал, түүний зохион байгуулалт, үйл ажиллагааг зохицуулна.

### Хоёр. Гишүүнчлэл

- 2.1. МЗСХ нь дараах гишүүнчлэлтэй байна. Үүнд:
  - 2.1.1. Загасчлалын спортын клубууд
  - 2.1.2. Загасчлалын төрлийн спортын холбоод
  - 2.1.3. Бүс, хот, орон нутгийн загасчлалын спортын холбоод
- 2.2. Гишүүнчлэлийн хүсэлтийг дараах байдлаар гаргана. Үүнд:
  - 2.2.1. Гишүүнээр элсэх хүсэлтийг МЗСХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр ирүүлнэ.
  - 2.2.2. МЗСХ-ны гишүүнээр элсэх хүсэлт нь энэхүү журмын шаардлагуудыг хангасан байх бөгөөд нэмэлт материалуудыг хавсаргасан байна.
  - 2.2.3. МЗСХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга нь тухайн хүсэлтийг хянан үзэж, Удирдах зөвлөлийн ээлжит хуралдаанаар оруулан шийдвэрлэнэ.

### Гурав. Гишүүнчлэлийн шалгуур

- 3.1. МЗСХ-ны гишүүн клуб, холбоо нь дараах нөхцлийг хангасан байна. Үүнд:
  - 3.1.1. Гишүүн клуб, холбоо нь Монгол улсын хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг байх.
  - 3.1.2. МЗСХ-ны дүрэм, журмууд, ОУОХ-ны ёс зүйн дүрэм болон холбогдох бусад дүрэм, журмыг баримтлан үйл ажиллагаагаа явуулдаг байх.
  - 3.1.3. МЗСХ-ны дүрэм, журмаар тогтоосон гишүүнчлэлийн хураамжийг тухай бүр төлдөг байх.
  - 3.1.4. МЗСХ-нд үйл ажиллагааны тайлангаа жил бүр гаргаж өгөх.

### Дөрөв. Гишүүдийн эрх, үүрэг

- 4.1. Гишүүд нь санал өгөх, сонгох, сонгогдох болон сонгуульд гишүүдийг нэр дэвшүүлэх эрхтэй.
- 4.2. Гишүүд нь МЗСХ-ны үйл ажиллагааны талаар мэдээлэл авах эрхтэй бөгөөд өөрсдийн үйл ажиллагааныхаа талаар мөн МЗСХ-нд тогтмол мэдээлэл өгөх үүрэгтэй.
- 4.3. Гишүүд нь үйл ажиллагаагаа хөгжүүлэх зорилгоор МЗСХ-ноос тусламж, дэмжлэг авах эрхтэй.
- 4.4. Гишүүд нь МЗСХ-ноос зохион байгуулж буй үйл ажиллагаа, уулзалтуудад идэвхтэй оролцох үүрэгтэй.
- 4.5. Гишүүд нь Монгол улсын хууль, МЗСХ-ны дүрэм, журмуудыг сахин биелүүлнэ.
- 4.6. Гишүүд нь МЗСХ-ны дүрэм, журам болон түүний заалтуудад нийцүүлэн гаргасан бүхий л шийдвэрийг хүндэтгэн хүлээн авч, хэрэгжүүлэх үүрэгтэй.
- 4.7. Гишүүн спортын холбоо, клуб нь хуваарьт тэмцээн, уралдааныг зохион байгуулдаг, хамтран оролцдог байна.
- 4.8. Гишүүн спортын холбоо, клубууд нь (Тив, ДАШТ-ээс бусад) бүс, хилийн чанад дахь загасчлалын спортын төрлүүдэд тамирчдаа бэлтгэх, сонгон шалгаруулах үйл ажиллагаа явуулахдаа МЗСХ-той хамтран ажиллана.
- 4.9. Гишүүд нь аль нэгэн комисс эсвэл ажлын хэсгийн бүрэлдэхүүнд багтаж, үүрэг гүйцэтгэж болно.
- 4.10. Гишүүд нь хуваарьт тэмцээн, уралдаан, үйл ажиллагаанд тухайн үеийн зохион байгуулагч нараас тогтоосон хураамж, төлбөрийг төлж оролцоно. Харин гишүүн бус спортын холбоо, клуб, хувь иргэн тэмцээн, уралдаанд оролцох бол тогтоосон хураамжийг 50%-иар нэмэгдүүлсэн хэмжээний төлбөр төлж оролцох бөгөөд тус нэмэгдүүлсэн орлогыг МЗСХ-ны дансанд төвлөрүүлнэ.
- 4.11. Гишүүд нь тус журам болон МЗСХ-ны бусад дүрэм, журмын заалтуудын дагуу эрх эдэлж, үүргээ биелүүлнэ.

## **Тав. МЗСХ-ны эрх, үүрэг**

- 5.1. Монгол улсад загасчлалын спортыг хөгжүүлэх, бодлогоор хангаж, үзэл баримтлалыг хэрэгжүүлэн ажиллах.
- 5.2. Байгал хүрээлэн буй орчин, загас амьтан хамгаалах, сурталчлан дэлгэрүүлэхэд тал бүрийн дэмжлэг үзүүлэх.
- 5.3. МЗСХ-ны гишүүн спортын холбоо, клубуудын үйл ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.
- 5.4. Жил бүр улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулдаг байх.
- 5.5. Тив, ДАШТ болон бусад ОУ-ын чанартай тэмцээн, уралдаанд тамирчдаа бэлтгэх, Монгол улсын шигшээ багийг бүрдүүлэх, сонгон шалгаруулах, шийдвэр гаргах, зохион байгуулж оролцуулах болон багийн гишүүдийн сахилга батыг хариуцах.
- 5.6. Тамирчдын тэмцээн уралдаанд үзүүлсэн амжилтаар ранкыг гаргаж, тогтмол шинэчлэн зарлах.
- 5.7. ОУ-ын болон Тив, ДАШТ зохион байгуулахаар нэрээ дэвшүүлж, хүсэлтийг ОУ-ын холбоонд хүргүүлэх.
- 5.8. Гадаад, дотоодын спортыг дэмжигч байгууллагууд, хандивлагч байгууллага ба иргэдтэй хамтран ажиллах, санхүүгийн шинэ эх үүсвэр бий болгох.
- 5.9. Загасчлалын спортод хувь нэмэр оруулсан хувь хүн, байгууллагыг МЗСХ-ны шагналаар шагнаж алдаршуулах, төр засгийн шагналд дэвшүүлэх.
- 5.10. Тамирчдын тэмцээн уралдаанд үзүүлсэн амжилтаар спортын цол зэрэг олгуулах, оны шилдэг тамирчин, шилдэг баг, клуб тодруулах.

## **Зургаа. Гишүүнчлэлийн бүртгэл**

- 6.1. Гишүүнчлэлийн бүртгэлийг Ерөнхий нарийн бичгийн дарга хийж, тогтмол шинэчилж байна. Энэ бүртгэлд дараах мэдээллүүд багтана. Үүнд: Гишүүний нэр, хаяг, утасны дугаар, и-мэйл, гишүүнчлэлийн хугацаа, харьяалагддаг хүний тоо, овог нэр, бусад мэдээлэл.
- 6.2. МЗСХ-ны гишүүнчлэл нь гишүүний жилийн хураамжтай байх бөгөөд дараах зохицуулалтыг мөрдөнө. Үүнд:
  - 6.2.1. Загасчлалын спортын холбоо, клуб нь МЗСХ-ны удирдах зөвлөлийн хурлаар тогтоосон гишүүний хураамжийг төлнө.
  - 6.2.2. Гишүүд гишүүний хураамжийг жил бүрийн 1-р улиралд багтаан МЗСХ-ны дансанд төвлөрүүлнэ.
  - 6.2.3. Гишүүний хураамжийг энэхүү журамд заасан хугацаанаас хэтрүүлсэн, төлөх боломжгүй болсон тохиолдолд МЗСХ-ны гишүүнээс хасах асуудлыг энэхүү журмын 6.6.3-т заасны дагуу шийдвэрлэнэ.
- 6.3. Гишүүн өөрийн хүлээсэн үүргийг хангалттай биелүүлж чадаагүй болон ОУОХ-ны Ёс зүйн дүрэм, МЗСХ-ны дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд, гаргасан зөрчил, учруулсан хохирлын хэмжээнээс хамааран дараах шийтгэлийн аль нэгийг оногдуулна.
  - 6.3.1. Сануулах
  - 6.3.2. Түдгэлзүүлэх
  - 6.3.3. Хасах
- 6.4. Гишүүнд аль нэг шийтгэл өгөх арга хэмжээ оногдуулахдаа тухайн гишүүнд тайлбар хийх боломж олгосны дараа МЗСХ-ны Удирдах зөвлөлийн хурлаас шийдвэрийг гаргана.
- 6.5. Гишүүнчлэлийн шалгуур нөхцөл (3-р зүйл)-ийг хангаагүйгээс бүрэн эрхийг нь түдгэлзүүлсэн болон гишүүнчлэлээс хасагдсан гишүүд нь тэдгээр нөхцлүүдийг хангасны дараагаар МЗСХ-ны Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр гишүүнчлэлээ сэргээж болно.
- 6.6. Гишүүнчлэл нь дараах тохиолдолд дуусгавар болно.
  - 6.6.1. Хуулийн этгээд татан буугдах
  - 6.6.2. Өөрийн хүсэлтээр гишүүнчлэлээс гарах (Энэ тухай хүсэлтээ бичгээр гаргана)
  - 6.6.3. Гишүүний үүргээ биелүүлээгүй тохиолдолд МЗСХ-ны Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр гишүүнчлэлээс хасах.

## **Долоо. Гишүүдийн хурал**

- 7.1. МЗСХ-ны удирдлагын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна.
  - 7.1.1. Гишүүдийн хурал
  - 7.1.2. Удирдах зөвлөл
  - 7.1.3. Ерөнхийлөгч
  - 7.1.4. Ерөнхий нарийн бичгийн дарга
- 7.2. Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч нь Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга байна.
- 7.3. Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга болон Удирдах зөвлөлийн үйл ажиллагааг “МЗСХ-ны удирдах зөвлөлийн журам”-аар зохицуулна.
- 7.4. Гишүүдийн хурал нь МЗСХ-ны эрх барих дээд байгууллага бөгөөд гишүүдийн хурлыг дөрвөн (4) жилд нэг удаа оны эхний хагаст багтаан хуралдуулна.
- 7.5. Гишүүдийн хурлыг хуралдуулах хугацааг хуанлийн арван дөрөв (14) хоногоос доошгүй хугацааны өмнө зарлах бөгөөд гишүүн холбоо, клуб нь оролцох төлөөлөгчийн нэр, бүртгэлийг хурал хуралдахаас хуанлын долоо (7) хоногийн өмнө МЗСХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргад ирүүлсэн байна.
- 7.6. Гишүүдийн хуралд гишүүн спортын холбоо, клубүүдээс тус бүр хоёр (2) төлөөлөгч, нийт нэг (1) саналын эрхтэйгээр оролцох эрхтэй.
- 7.7. Гишүүдийн хуралд Хүндэт ерөнхийлөгч, Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга, Удирдах зөвлөлийн гишүүд тус бүр нэг (1) саналын эрхтэйгээр оролцоно.
- 7.8. Гишүүдийн хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:
  - 7.8.1. Өмнөх дөрвөн (4) жилийн хугацааны тайлан
  - 7.8.2. Ерөнхийлөгч болон Удирдах зөвлөлийн гишүүдийн сонгууль
- 7.9. Ерөнхийлөгч болон Удирдах зөвлөлийн гишүүдийн сонгуулийг дараах аргачлалаар явуулна.
  - 7.9.1. Гишүүд нь Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх бол гишүүдийн хурал зарлагдсанаас хойш, хурал хуралдахаас хуанлын долоо (7) хоногийн өмнө МЗСХ-ны Ерөнхий нарийн бичгийн даргад бичгээр, нэр дэвшигчийн товч танилцуулгын хамт ирүүлсэн байна.
  - 7.9.2. Дээрхи албан тушаалд нэр дэвших хүн нь гишүүдийн хуралд оролцох төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд багтсан байна.
  - 7.9.3. МЗСХ-ны Ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд нэр дэвшигчдийн товч танилцуулгыг гишүүдийн хурал дээр мэдээлж, хэвлэмэл хуудсаар хайрцагт санал авна.
  - 7.9.4. Нэр дэвшигчийг сонгуульд оролцуулахаас татгалзуулах саналтай гишүүн байгаа эсэх болон нэр дэвшигчийн сонгогдох эрхийн талаар маргаан гарсан тохиолдолд хуралд мэдэгдэж, энэ талаар хэлэлцэн, олонхын саналаар шийдвэрлэж, эцсийн шийдвэр гарсаны дараа сонгуулийг явуулна.
  - 7.9.5. Ерөнхийлөгчид нэр дэвшигч нийт саналын тавь (50)-иас дээш хувийг авсан тохиолдолд сонгогдсонд тооцно. Хэрэв нэр дэвшигчдийн хэн нь ч тавь (50)-иас дээш хувийн санал аваагүй тохиолдолд хамгийн олон санал авсан хоёр (2) нэр дэвшигчийг үлдээж, дахин санал хурааж шийдвэрлэнэ. Дахин санал хураалтанд нийт саналын тавь (50)-иас дээш хувийн санал авсан нэр дэвшигч сонгогдсонд тооцно. Саналын тоо тэнцсэн тохиолдолд дахин санал хураалт явуулан, илүү саналтай нь сонгогдох зарчмыг баримтална.
  - 7.9.6. МЗСХ-ны Удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшүүлэн, авсан саналын тоог харгалзан хамгийн олон санал авсан долоон (7) гишүүнийг сонгоно. Саналын тоо тэнцсэн тохиолдолд тэнцсэн нэр дэвшигчдийн дунд дахин санал хураалт явуулж шийдвэрлэнэ.
  - 7.9.7. МЗСХ-ны Удирдах зөвлөл нь сонгогдсон долоон (7) гишүүн болон Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга гэсэн нийт есөн (9) хүний бүрэлдэхүүнтэй байна. Мөн Хүндэт ерөнхийлөгчид тоонд хязгаарлагдахгүйгээр оролцох эрхтэй.
- 7.10. Шаардлагатай тохиолдолд МЗСХ-ны гишүүдийн ээлжит бус хурлыг Удирдах зөвлөлийн бичгээр гаргасан санал, шийдвэрийг үндэслэн хугацаанаас нь өмнө зарлан хуралдуулж болно. Ээлжит бус хурал нь ээлжит хуралтай ижил горимоор болно.
- 7.11. МЗСХ-ны гишүүдийн хурлыг Ерөнхийлөгч даргална. Ерөнхийлөгч эзгүйд болон ажил үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн дарга хурлыг удирдан явуулна.

- 7.12. МЗСХ-ны гишүүдийн хурлын тэмдэглэлийг Ерөнхий нарийн бичгийн дарга хөтөлнө. Түүний эзгүйд, эсвэл тэмдэглэл хөтлөх боломжгүй байгаа тохиолдолд хурал даргалагчийн томилсон гишүүн хөтөлнө.
- 7.13. МЗСХ-ны гишүүдийн хурал нь нийт гишүүдийн талаас доошгүй ирцтэй байх тохиолдолд хуралдана. Хэрвээ дээрх нөхцөл хангагдаагүй тохиолдолд хурлыг долоо (7) хоногоор хойшлуулан зарлана. Хоёр дахь хурал хүчин төгөлдөр болох нөхцлийг хангаж чадаагүй бол дараагийн хурлыг нийт гишүүдийн гуравны нэгээс (1/3) доошгүй бүрэлдэхүүнтэй тохиолдолд хуралдуулна.